



Урл 27 2016 3037  
БАРИЛГА,  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН  
ТУШААЛ

2016 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 79

Улаанбаатар хот


Журам, загвар батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хориглох дохио тэмдэг хэрэглэх журам"-ыг нэгдүгээр, "Төрийн өмчийн газарт бэхлэх хориглох дохио тэмдгийн загвар"-ыг хоёрдугаар, "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтын газарт бэхлэх хориглох дохио тэмдгийн загвар"-ыг гуравдугаар, "Хориглох дохио тэмдгийг газарт бэхэлсэн тухай актын загвар"-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газар /Б.Ууганбаяр/-т, орон нутаг дахь газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, нийтэд сурталчлан, хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар /А.Хүрэлшагай/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД



З.БАЯНСЭЛЭНГЭ



Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны  
05 дугаар сарын 05 ны өдрийн 79 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

## ХОРИГЛОХ ДОХИО ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Газрын тухай хуулийн 48 дугаар зүйдийн 48.1 дэх хэсэгт заасан хориглох дохио тэмдгийн загвар, түүнийг хэрэглэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад энэ журмын зорилго нь оршино.

1.2. "Хориглох дохио тэмдэг" гэж төрийн өмчийн болон иргэн, аж ахуй нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаа газарт зөвшөөрөлгүйгээр нэвтрэх, дайран өнгөрөх, үйл ажиллагаа явуулахыг хориглосон тэмдгийг ойлгоно.

1.3. Сум, дүүргийн Засаг дарга нь тухайн жилд төрийн өмчийн газарт байршуулах хориглох дохио тэмдгийн судалгаа, холбогдох зардлын тооцооллыг гаргаж, дүүрэг сумын тухайн жилийн газар газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, батлуулна.

1.4. Хориглох дохио тэмдэг байршуулахтай холбогдон гарах ажлын үнэлгээг Засгийн газар тогтооно.

### Хоёр. Хориглох дохио тэмдгийн төрөл

2.1. "Хориглох дохио тэмдэг" нь "Төрийн өмчийн газарт байршуулах хориглох дохио тэмдэг", "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтын газарт байршуулах хориглох дохио" гэсэн хоёр төрөлтэй байна.

2.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшил, ашиглалтын газарт хориглох дохио тэмдгийг байршуулж болно.

2.2.1. Тухайн шатны Засаг дарга иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хориглох дохио тэмдэг байршуулах тухай хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэнэ.

2.2.2. Аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал тухайн шатны Засаг даргын шийдвэрийг үндэслэн дохио тэмдэг байршуулах ажлыг зохион байгуулна.

2.2.3. Иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь хориглох дохио тэмдгийг батлагдсан загварын дагуу хийлгэж, байршуулах зардлыг хариуцна.

2.2.4. Аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал хориглох дохио тэмдгийг газарт бэхэлсэн тухай актыг 2 хувь үйлдэж, 1 хувийг газар эзэмшигч, ашиглагчид хүлээлгэж өгнө.

### **Гурав. Хориглох дохио тэмдгийг байршуулахад тавигдах шаардлага**

3.1. Хориглох дохио тэмдэг байршуулахад дараах шаардлага тавигдана.

3.1.1. Хориглох дохио тэмдгийг газрын гадаргаас дээш 2 м-ийн өндөрт, эгц босоогоор, олон нийт чөлөөтэй зорчих гол гудамж, замруу харуулан харагдахуйц байдлаар бэхэлж, байршуулна.

3.1.2. Газар ашиглалтын зориулалт, хэмжээ, байршил, гадаргын төлөв байдал, гол гудамж, замаар зорчигчид харагдах байдлыг харгалзан 1-4 ширхэг хориглох дохио тэмдгийг байршуулна.

3.1.3. Шаардлагатай тохиолдолд хориглох дохио тэмдэгтэй хамт тухайн газрын хил заагийг тойм байдлаар харуулсан нэмэлт тэмдэглэгээг бэхэлж болно.

3.2. Сумын газрын даамал, дүүргийн газрын алба нь газарт бэхэлсэн хориглох дохио тэмдгийн байршлыг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэнэ.

### **Дөрөв. Бусад**

4.1. Тухайн газрын эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэн авсан этгээд хориглох дохио тэмдгийг өөрчлүүлэх хүсэлт гаргаагүй бол байршуулсан хориглох дохио тэмдгийг хүчинтэй гэж үзнэ.

4.2. Иргэн, аж ахуй нэгж байгууллага нь өөрийн эзэмшиж, ашиглаж байгаа газарт байршуулсан дохио тэмдгийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, хамгаалалтыг хариуцна.

4.3. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Газрын тухай хуулийн 60 дугаар зүйл болон Иргэний хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Handwritten signature and stamp on the right margin.

Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны  
05 дугаар сарын 06 ны өдрийн 79 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ БЭХЛЭХ  
ХОРИГЛОХ ДОХИО ТЭМДГИЙН ЗАГВАР



A1 Arial 100 pt Цагаан

A2 Arial 200 pt Улаан

A3 Arial 72 pt Цагаан

Самбарын дэвсгэр өнгө нь гүн хөх (RGB 0, 31, 127)


Нэмэлт самбарын дэвсгэр өнгө нь ногоон (RGB 0, 200, 15)

Ø Самбарын хөлний диаметр 50 мм



Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны  
05 дугаар сарын 08-ны өдрийн 79 дугаар  
тушаалын туравдугаар хавсралт

ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭЗЭМШИЛ, АШИГЛАЛТЫН ГАЗАРТ  
БЭХЛЭХ ХОРИГЛОХ ДОХИО ТЭМДГИЙН ЗАГВАР



A1 Arial 100 pt Хар

A2 Arial 200 pt Улаан

A3 Arial 72 pt Хар

Самбарын дэвсгэр өнгө нь гүн хөх (RGB 0, 31, 127)

Нэмэлт самбарын дэвсгэр өнгө нь ногоон (RGB 0, 200, 15)

Ø Самбарын хөлний диаметр 50 мм



Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны  
 05 дугаар сарын 25-ны өдрийн 79 дугаар  
 тушаалын дөрөвдүгээр хавсралт

ХОРИГЛОХ ДОХИО ТЭМДГИЙГ ГАЗАРТ  
 БЭХЭЛСЭН ТУХАЙ АКТ

Д/д	Иргэний овог нэр / хуулийн этгээдийн нэр:	
1	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар:	
2	Регистрийн дугаар:	
3	Байнгийн хаяг:	
4	Газрын баяршлын хаяг:	
5	Холбоо барих утас	
6	Эрхийн хэлбэр (Холбогдох дугаарыг дугуйл):	1. Эзэмших 2. Ашиглах
7	Газар эзэмших (ашиглах) хугацаа (жил):	
8	Газарт бэхэлсэн хориглох дохио тэмдгийн тоо:	
9	Газарт бэхэлсэн огноо:	
10	Газарт бэхэлсэн байгууллагын нэр:	
11	1. Хориглох дохио тэмдгийн координат:	X= ..... Y= .....
	2. Хориглох дохио тэмдгийн координат:	X= ..... Y= .....
	3. Хориглох дохио тэмдгийн координат:	X= ..... Y= .....
	4. Хориглох дохио тэмдгийн координат:	X= ..... Y= .....
12	Хориглох дохио тэмдгийг газарт бэхэлсэн байдлын фото зураг	
Хүлээлгэн өгсөн:		Хүлээн авсан:
..... /..... ..... Нэр	Хориглох дохио тэмдгийг газарт бэхэлсэн мэргэжилтэн ..... ..... /Байгууллагын нэр/	..... /..... ..... Нэр /Байгууллагын төлөөлж

Анхааруулга:  
 Газарт бэхэлсэн хориглох дохио тэмдэгтээ 5-10 жилийн баталгаа өгч тухайн хугацаанд гадны хүчин зүйлийн нөлөөгүйгээр унасан, газарт суулгасан бэхэлгээ суларснаас гадна харагдах байдалд өөрчлөлт орсон тохиолдолд хориглох дохио тэмдгийг тухайн иргэн, аж ахуй нэгж засварлах ажлыг харууцна.